

“ӨНДӨРХААН” ХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 11 сарын 19-ний өдөр

№24/11

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
бус хурлын товыг өөрчлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсэг, 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам” болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- “Өндөрхаан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 10:00 цагт танхимаар хуралдуулах хурлыг 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 10:00 цагт танхимаар болгон өөрчилсүгэй.
- Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
- Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөр тогтоосугай.
- Хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2024 оны 11 дүгээр сарын 22-ний өдрийн дотор хүргүүлсүгэй.
- Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, холбоотой бусад баримт бичгийг бэлэн болгож 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.

7. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 18:00 цагаар тасалбар болгосугай.

8. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг

Хурал байгуулах комиссын гишүүд:

Гүйцэтгэх захирал Ц.Тайшир

9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга:

Б.Батжаргал Барристер Кастос Хуулийн фирм

Тооллогын комиссын гишүүн:

Г.Энхжин Барристер Кастос Хуулийн фирм

Ц.Энхбаяр Барристер Кастос Хуулийн фирм

10. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

12. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан 2024 оны 11 сарын 13-ны өдрийн 24/13 дугаартай тогтоолыг хүчингүй болгосугай.



Ч.ГАНХУЯГ